

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



[www.audit.mn](http://www.audit.mn)

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2020 ОН



Газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: **Б.Мөнхбат**  
Утас: 99007576 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: **А.Цээням**  
Утас: 99442140 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Баянхонгор 2020 он

## АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт.....	3
Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудит: .....	7
Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудит: .....	11
Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар: .....	15
Тавдугаар бүлэг. ИТХ-ын захиалга болон өөрийн санаачилга: .....	19
Зургаадугаар бүлэг. Дотоод ажил .....	22
Долдугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл: .....	28

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020.12.16

**Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт:**

Үндэсний аудитын газраас 2020 оныг **“Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн”** жил болгосон зорилтын хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь дотоод сургалтын болон бусад */МУЕА-ын албан даалгавар, Авлигатай тэмцэх хөтөлбөр, ББНШК-н гэх мэт/* ажлын дэд төлөвлөгөөгөө боловсруулан тусгагдсан ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд ажлаа чиглүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.



Зорилтыг хангах ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

❖ 2020.06.01-ны өдрөөс дагаж мөрдөхөөр батлагдсан Төрийн аудитын тухай /шинэчилсэн найруулга/ хуулиар ҮАГ-ын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудиторыг урьж албан хаагчдад хичээл заалгасан бөгөөд аймаг орон нутгийн удирдлагууд, ТЕЗ, ТТЗ, ТШЗ нарт Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдсэн хуулийг нэг бүрчлэн хүргүүлэхийн зэрэгцээ хуулийн талаарх сурталчилгаа, мэдээлэл хийсэн. Үүний үр дүнд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2021 оны төслийн төсөлдөө дүгнэлт гаргуулахаар Төсвийн тухай хуульд зааны дагуу 2020.11.20-нд Төрийн аудитын газарт ирүүлсэн.

❖ Монгол улсын үндэсний стандартаар 2020.01.13-нд батлагдсан MNS 6817:2020 стандартыг 2020.01.15-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд аудитын чанар, стандартын шинэтгэлийн зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтын самбарыг шинэчлэн боловсруулан аудитын үе шат бүрд үнэлгээ өгч ажиллалаа.

❖ Байгууллагын 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянах зорилгоор календарьчилсан төлөвлөгөөний самбар гаргаж, төлөвлөгөөний биелэлтэд Тэргүүлэх аудитор хяналт тавин ажилласан.

❖ Ажилтнуудын өдөр тутмын ажлын удирдлага зохион байгуулалтыг дотоод удирдлагын ABLE системийг бүрэн ашиглан 7 хоногоор хийх ажлын төлөвлөгөө болон үүрэг даалгаврын биелэлтэд шуурхай хурлаар хэлэлцэх байдлаар хяналт тавин ажиллаж байна.



Үүний үр дүнд цаасгүй, цахим технологид ажилтнууд суралцаж, төрөлжсөн аудитын баг хооронд болон удирдлагын зүгээс үүрэг даалгаврыг бүрэн цахим болгоод байна.

Мөн албан бичгийн эргэлтийг ABLE программыг ашиглан хэрэгжүүлснээр цохолттой бичгийг дахин хувилж холбогдох ажилтанд өгөх байдал бүрэн арилж цаг хугацаа, материалыг тодорхой хэмжээгээр хэмнээд байна.

❖ Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг **“Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн”** жилийн зорилтод нийцүүлэн боловсруулж сургалтын сэдвийг АЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Шүүх, Прокуророос мэргэжлийн хуульч урих, аудитын стандарт, дүрэм журам арга аргачлалыг ажилтнуудад хуваарилан өгч сургалтыг хийж буй аудиттай уялдуулан кейс ажиллах, ярилцлага хийж санал солилцох зэргээр ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Тус газар нь 2020 онд Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан бүтэц, зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж, Газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор, хэлтсийн дарга аудитын менежер, ахлах аудитор 3, аудитор 5, жолооч 1 нийт 11 орон тоотой ажиллалаа. Мөн гэрээтээр нярав, бичгийн хэргийн ажилтан ажиллаж байна.

2020 оны жилийн дүнгээр нийт 20128 хүн/цаг ажиллахаас 22034 хүн/цаг ажиллаж, 1906 хүн,цаг илүү цагаар ажилласан байна.



**2020 онд гүйцэтгэсэн аудитын үр дүн:**

Тайлант хугацаанд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.8-д заасан хугацаанд нийт 156 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргаж, үүнээс 133 байгууллага “Зөрчилгүй”, 19 “Хязгаарлалттай”, 2 “Сөрөг”, 2 “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт гаргаж, 1 байгууллага санхүүгийн тайлангаа гаргаж ирүүлээгүй. Дээрх өөрчлөлттэй дүгнэлт авсан 21 байгууллагын удирдлагад “Төрийн аудитын тухай хууль”-ийн 28 дугаар зүйлд зааснаар сахилгын шийтгэл ногдуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хэрэгжүүлж ажиллав.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар төлөвлөгөөт гүйцэтгэлийн 4 аудит, нийцлийн 6 аудит, аймгийн ИТХ-ын захиалгаар нийцлийн 2 аудит, өөрсдийн санаачилгаар гүйцэтгэлийн 2 аудит, буюу нийтдээ гүйцэтгэлийн 6 аудит, нийцлийн 8 аудитыг тус тус гүйцэтгэж, тайлан, судалгааг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлсэн.

2020 онд хийгдсэн санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитаар нийт 23145.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 1220,9 сая төгрөгийн 198 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 6266.4 сая төгрөгийн 136 албан шаардлага хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгах, дахин давтахгүй байхад чиглэсэн 11416.2 сая төгрөгийн 381 заалт бүхий зөвлөмж өгч, 4241,5 сая төгрөгийн 80 алдааг санхүүгийн тайланд залруулсан /хүснэгт №1/.

Тайлант онд нийтдээ 8853.7 сая төгрөгийн үр өгөөж тооцсон бөгөөд Орон нутгийн захиргааны болон холбогдох байгууллагууд хүлээн зөвшөөрсөн ба зардлын 1 төгрөг тутмаас 21.93 төгрөгийн үр өгөөж гарсан байна.

Хүснэгт №01. Илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

/сая.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТОГТООСОН		ХЭРЭГЖСЭН		
	Тоо	дүн	Тоо	дүн	Хувь
ТӨЛБӨРИЙН АКТ	198	1220.9	177	1057.7	86.6
АЛБАН ШААРДЛАГА	136	6266.4	117	5896.4	94.1
ЗӨВЛӨМЖ	381	11416.2	346	10723.2	74.4
ЗАЛРУУЛГА	80	4241.5	80	4241.5	100.0
ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ САНАЛ	21		21		100.0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>816</b>	<b>23145.0</b>	<b>741</b>	<b>21918.8</b>	<b>91.0</b>

Жилийн эцсийн байдлаар актын төлбөрийг 86.5 % буюу 1057.7 сая төгрөгийг, албан шаардлагын 94.1% буюу 5896.4 сая.төгрөгийг тус тус барагдуулснаас актын төлбөрөөс 253,0 сая төгрөгийг орон нутгийн орлогод, 614,9 сая төгрөгийг бусад сан, 189.8 сая төгрөгийг тухайн байгууллагад төвлөрүүлсэн, 10723.2 сая төгрөгийн 346 зөвлөмж хэрэгжиж, нийт дүнгээр зөвлөмжийн хэрэгжилт 74.4% нийт дүнгээр 91%-тай байгаа нь төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэлийн болон нийцлийн аудитууд 3, 4-р улиралд хийгдсэнээс хэрэгжилт тооцох хугацаа болоогүй, мөн дэлхий нийтэд Ковид цар тахал гарч хөл хорио тогтоосны



улмаас Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн үйл ажиллагаа тасалдах, орлого багассан шалтгааны улмаас Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан иргэдэд тогтоосон төлбөрийн актын хугацааг хойшлуулснаас шалтгаалсан болно.

### Орон нутгийн 2021 оны төсвийн төсөл өгсөн дүгнэлт:

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.3.2 -т заасныг үндэслэн “Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал хорогдуулах, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх”-д дүгнэлт гаргах ажлын хэсгийг 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 28 хүн/өдөр 64 цаг илүү ажилласан.


Дүн шинжилгээний аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу орлого, зардал, хөрөнгө оруулалт, сангаар нь задлан шинжилж төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх 530.2 сая, зардлыг бууруулах 1473,4 сая, төсвийн үр ашгийг дээшлүүлэх 5011.4 сая төгрөгийн нийт 7012.7 сая төгрөгийн 17 санал, дүгнэлт гаргаж Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-ын ээлжит 2020 оны II хуралдаанаар дээрх дүгнэлтийг асуудал нэг бүрээр хэлэлцэж төсвийн орлогыг нэмэгдүүлэх 346.2 сая, төсвийн үр ашгийг дээшлүүлэх 4000.4 сая, төсвийн зарлагыг бууруулах 1177.7 сая төгрөгийн нийт 5524.3 сая төгрөгийн 13 саналыг асуудал тус бүрээр хүлээн авсан тухай тайлбарын хамт Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 1а/433 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### Шинээр хэрэгжүүлсэн бүтээлч ажил:

Тус гарын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6.6-д “2020 онд хийгдсэн санхүү, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайлан, холбогдох бусад баримтыг DVD-нд бичиж, цахим баримтын сан үүсгэх.” гэж заасан арга хэмжээний хүрээнд 2020 онд аудиторуд, хувийн аудитын компанийн гүйцэтгэсэн аудитын 184 тайлан, гүйцэтгэлийн аудитын 4, нийцлийн аудитын 7 ажлын баримтыг /word, excel, pdf гэх мэт боломжтой хэлбэрээр нь/ цахим архивын нэгж үүсгэн DVD болон тусгай компьютерт байршуулан цахим сан үүсгэсэн.

### Цахим хэлбэрээр хадгалж буй баримт:



Энэ арга хэмжээ нь Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны гол бүтээгдэхүүн болох аудитын тайланг цаасан архиваас татаж үзэхэд цаг хугацаа их шаарддаг байсныг аудитын бүх үе шатны баримтыг цахим хэлбэрээр түргэн шуурхай татаж үзэх боломжтой болсноор төсвийн хууль тогтоомж зөрчигдсөн асуудалд энэ сангаасаа иргэдэд түргэн шуурхай хариу өгөх, лавлагаа гаргах ач холбогдолтой болсон. Энэ ажил нь цаашид бидний зорьж буй Төрийн аудитын байгууллагын цахим сангийн эхлэл нь болж байна.

### Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудит:

Аймгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсөвт байгууллага, тусгай сан, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 265 байгууллага санхүүгийн тайлан гаргахаас “Баянхонгор Нью майнинг” ХХК Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд санхүүгийн тайлан гаргаж ирүүлээгүй тул аудит хийгдээгүй болно.


Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанд аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, 18 сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн

болон Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Халамжийн сан /улсын төсөв/ зэрэг нийт 21 төсвийн төвлөрүүлэн захирагч, аймгийн Засаг даргын харьяаны 110, бусад ерөнхийлөн захирагчийн харьяа 24, нийт 156 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргаж, 84 байгууллагыг түүвэрт хамруулан шалгаж, 24 байгууллагад итгэл үзүүлэв.

Аудит хийж дүгнэлт гаргасан байгууллагын тоо өмнөх оноос 18-аар буурсан нь түүвэрт хамрагдсан байгууллагын тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.


Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан 204 байгууллага, аж ахуйн нэгж, тусгай сан, сумдын санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн аудитын байгууллагын үндсэн болон гэрээт аудиторуд аудит хийж, 36 байгууллагын санхүүгийн тайланд хувийн аудитын “Хонгорын үр сад аудит”, “Глобал капитал аудит” компаниуд гэрээ байгуулж, аудит хийсэн.

Аудитад Төрийн аудитын байгууллагын 10, хараат бус аудитын 2 компанийн 8, /давхардсан тоогоор 36 хүн/ нийт 18 хүн, 142 өдөр, 1116 хүн/өдөр ажиллаж, 1461 илүү цаг зарцуулсан байна.



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР ДҮН:**

Аудитад хамрагдаж, дүгнэлт гаргасан нийт 156 байгууллагын санхүүгийн тайлангийн 84% буюу 133 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, 13% буюу 19 тайланд “Хязгаарлалттай”, Бөмбөгөр, Бууцагаан сумын ЗДТГ-т “Сөрөг”, “Баянхонгор хайрхан фарм” ОНӨААТҮГ, “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт гаргасан байна.



Аудитын дүнд үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй санал дүгнэлт авсан 21 байгууллагын төсвийн менежер нарт сахилгын шийтгэл ногдуулах саналыг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлж, “Хонгор шинэ агро” ОНӨААН-ийн удирдлагаас бусад албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажилласан байна.

**АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 10555.8 САЯ.ТӨГ**





САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЗАЛРУУЛГА



Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагын нийт зөрчлийн тоог өмнөх онтой харьцуулахад алдаа зөрчлийн дүн 7081.4 сая төгрөгөөр нэмэгдэж, зөрчилтэй санал дүгнэлт авсан байгууллагын тоо өмнөх оноос 16-аар

нэмэгдсэн тул зөрчлийг арилгах 13 зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж ажилласан.

2020 оны байдлаар албан шаардлагаас 94.4 хувь буюу 2786.3 сая төгрөг, төлбөрийн актаас 85.7 хувь буюу 878.3 сая төгрөгийг барагдуулж, 183 зөрчилд 1,406.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцсоныг төсвийн захирагчид хүлээн зөвшөөрсөн, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар аймгийн ХХААГ-т сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлд тавих хяналтыг сайжруулахтай холбоотой санхүүгийн бус 1 үр өгөөжийг тооцож ажилласан. Өмнөх оны 1 албан шаардлагын 10.0 сая төгрөг барагдаагүй байсныг тайлант онд бүрэн барагдуулав.

Тайлант онд 152.5 сая төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгслийн гэрчилгээ төсөвт байгууллагуудын нэр дээр шилжиж ирээгүй зөрчилтэй холбоотой 4 албан шаардлага, 13.4 сая төгрөг нь Баянхонгор, Баацагаан сумын Сум хөгжүүлэх сангийн төлөгдөөгүй зээлтэй холбоотойгоор 2 албан шаардлага биелээгүй байна.

Дэлхий нийтэд Ковид цар тахал гарч хөл хорио тогтоосны улмаас Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн үйл ажиллагаа тасалдах, орлого багассан шалтгааны улмаас Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан иргэдэд тогтоосон төлбөрийн актын биелэлтийн хугацааг хойшлуулснаас 8 сумын 128.6 сая төгрөгийг дараа онд шилжиж төлөгдөхөөр болж байна.

Аудитаар 2337.4 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байхад чиглэсэн 294 заалт бүхий зөвлөмжийг 126 байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлсэн ба “Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах сарын аян” зохион байгуулж ажилласны үр дүнд Гурванбулаг сумын ИТХ-ын өмнөх оны 2.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмжөөс бусад 2335.4 сая төгрөгийн 292 зөвлөмжийн хэрэгжилтийг албан бичгээр авч, зөвлөмжийг 99.9 хувь биелүүлж ажиллав. Гурванбулаг сумын ИТХ-ын барагдаагүй 2.0 сая төгрөгийн авлагыг тодруулахаар аймгийн МХГ, ШШГГ, Шүүхийн Тамгын газарт албан бичиг хүргүүлж 1.0 сая төгрөгийн зөрчлийг арилгасан үлдэгдлийг барагдуулах ажлыг хийж байна. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019.11.12-ний өдрийн “Санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэл батлах тухай” А/87 дугаар тушаал, Ерөнхий аудиторын орлогч бөгөөд Тэргүүлэх аудиторын 2019.12.13-ний өдрийн 02/2055

дугаар албан бичгээр “Төрийн аудитын байгууллагаас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэлийг аудитад ашиглах аргачлал, зөвлөмж”-ийн дагуу Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн ажлын тайлан, хавсралт судалгаануудын хамт бэлтгэн 2020.05.15-ны өдөр ҮАГ-ын СУГ-т хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий аудиторын тайлант хугацаанд баримтлах ерөнхий чиглэлийг шалгах явцад суудлын автомашины ашиглалтын талаар албан бичгийг холбогдох газруудад хүргүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2020.06.25-ний өдрийн А/409 дүгээр захирамжаар “Орон нутгийн өмчит байгууллагуудад бүртгэлтэй суудлын автомашин тоо төрөл тогтоох, ашиглах, эзэмших журам”-ыг баталж мөрдөж эхэлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд СТАУС программыг хөгжүүлэх, боловсронгуй болгох 33 санал болон аудитын 14 чиглэлээр нийт 43 эрсдэлийн санг бэлтгэж СУГ-т 2020.10.12-ны өдөр 1/717 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020.05.21-ний өдрийн 01 дүгээр “Санхүүгийн тайлангийн аудит хийх бэлтгэл ажлын талаар” албан даалгаврын дагуу нийт 11 ажил хийх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулан, албан даалгаврын хэрэгжилтийг гаргаж, 2020.10.12, 2020.11.30-ны өдөр Үндэсний аудитын газарт албан бичгээр хүргүүлсэн.

Төсөвт байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайланд хийх завсрын аудитыг 2020.11.05-аас эхэлж 4 аудитор 4 сумын 24 байгууллага, 8 аудитор аймгийн төвийн 48 байгууллага, нийт 72 байгууллагад завсрын аудитыг хийж, СТАУС программд төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатны ажлыг оруулж, чанарын хяналтыг хэрэгжүүлж ажиллав.

ҮАГ-ын 2020.11.10-ний өдрийн 06/74 дүгээр албан бичгийн дагуу санхүүгийн тайлангийн аудитын арга зүйгээр хангуулах, хамтран ажиллах хүрээнд санхүүгийн аудитын арга зүйн дэмжлэг үзүүлэхэд зохион байгуулах ажилд 7 санал, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой тулгарч буй хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах асуудалд 8 санал, аудитын хуулийн этгээдтэй хэрхэн хамтарч ажиллах болон аудитын чанарын талаар 5 саналыг 2020.11.25-ны өдөр 1/760 дугаар албан бичгээр ҮАГ-ын САГ-т хүргүүлэв.

ҮАГ-ын ЧБА-аас өгсөн чиглэлийн дагуу аудитын төлөвлөх үе шатанд аудитын үр өгөөжийг тооцох маягт боловсруулан хянуулсан ба дарга бөгөөд Тэргүүлэх аудитор, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежерээс тавих хяналтыг нэгтгэсэн хяналтын хуудсыг бэлтгэж, аудиторуудад хүргүүлж, мөрдөн ажиллаж байна.

#### **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ:**

- Өмнөх жилээс зөрчилтэй санал дүгнэлт авсан байгууллагын тоо, зөрчлийн дүн нэмэгдсэн байсанд санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах зөвлөмжийг хүргүүлсний дагуу аймгийн СТСХ-ээс “Тунгалаг санхүү” хөтөлбөрийн хүрээнд төсвийн байгууллагуудын нягтлан бодогч, нярвуудыг хамруулан “Ажлын байрны сургалт”, нягтлан бодогч нарыг

“Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт-Харилцааны ур чадвар” сэдэвт Сангийн яамны сургалт, шинээр томилогдсон нягтлан бодогчдод чадавхжуулах сургалт, нярвуудад чадамжийн гэрчилгээтэй сургалтуудыг зохион байгуулж ажилласан байна.

- Зээлийн батлан даалтын санд өмнөх онуудад орон нутгийн төсвөөс олгосон 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгож хамтран ажиллах гэрээ байгуулсан байхад орон нутгийн иргэдэд хөнгөлөлттэй зээл олгоогүй байсан зөрчилд аудитаар зөвлөмж өгсний дагуу 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг Зээлийн батлан даалтын сангаас "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац" ХХК-ийн дансанд төвлөрүүлж, тус эх үүсвэрээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт зээл олгож, аудитын үр өгөөж гарсан байна.

- Аудитын зөвлөмжийн дагуу сүүлийн 2 жилд санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албаар хяналт шалгалт явуулах зөвлөмж, түүний дагуу татан буулгах тухай албан бичиг хүргүүлсний дүнд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.03.04-ний 18 дугаар тогтоолоор “Нью майнинг” ХХК, 2020.09.14-ний өдрийн 88 дугаар тогтоолоор “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ыг татан буулгасан байна.

- Аймгийн ХХААГ-ын сум хөгжүүлэх сан, хоршоо хариуцсан мэргэжилтэнд чиглэл өгч, хамтран ажилласны үр дүнд сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүд тавих хяналт сайжирч, зээлийг төлүүлэх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх ажил эрчимжсэн байна.

- Орон нутгийн өмчит 75 байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгасан 84.5 сая төгрөгийн цаашид ашиглах боломжгүй ашиглалтгүй биет бус хөрөнгийг акталж данснаас хассан байна.

### Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудит:

Тайлант хугацаанд УАГ-ын нэгдсэн удирдамжаар 4 аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 11 аудитор 90 өдөр 128 илүү цаг, 275 хүн/өдөр, 45.3 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэв.

#### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН:

Гүйцэтгэлийн аудитаар нийт 9,068.0 сая төгрөгийн 46 зөрчил илрүүлснээс 11 зөрчилд 157.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 11 зөрчлийн арилгах 1,005.8 сая төгрөгийн албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 7,904.7 сая төгрөгийн 24 зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг тооцсон.

Гүйцэтгэлийн аудитын илрүүлэлт 9068,0 сая төгрөг



Хүснэгт№02 Гүйцэтгэлийн аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

№	Аудитын нэр	Акт				Албан шаардлага				Зөвлөмж			
		тоо	тогтоосон	барагдсан	хувь	тоо	өгсөн	биелсэн	хувь	тоо	өгсөн	биелсэн	хувь
1	Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг.	4.0	132.5	132.5	100	2.0	950.0	950.0	100	7.0	7556.1	7556.1	100
2	Сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах.	1.0	0.8	0.8	100	1.0	2.1	2.1	100				
3	Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх.	3.0	2.6	2.6	100	3.0	45.7	45.7	100				
4	Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн.	3.0	21.6	16.1	75	5.0	8.0	8.0	100	17.0	348.6		
	Нийт	11.0	157.5	152.0	94	11.0	1005.8	1005.8	100	24.0	7904.7	7556.1	100

**ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ:**

“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу дараах үр нөлөө гарч байна.

**Тухайлбал:**

- Төсөв батлагдах үед магадлалаар ТЭЗҮ, зураг төсвийг баталгаажуулаагүйгээс нэмэгддэг байдлыг арилгах, багасгах зөвлөмж өгснөөр 2020 оны төсөвт 39129,9 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээний зураг төсөвт бүрэн магадлал хийгдсэн тул төсөв нэмэгдэх эрсдэлгүй болсон.
- Төсөл сонгон шалгаруулах үнэлгээний хороог шуурхай зохион байгуулснаар төсөл арга хэмжээ хэрэгжих улирлын нөхцөл байдлаас шалтгаалж ажил зогсох, он дамжин гүйцэтгэх, гүйцэтгэлийн хугацаа удааширснаас төсөв нэмэгдэх эрсдэл буурч 2020 оны

улсын төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээний хороог 2020.02.20-нд бүрэн байгуулж дууссан.

- Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд тулгуурлан өгөөгүйгээс 950.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байсан бөгөөд төсөл, арга хэмжээнд тавих зохиогчийн хяналтыг үе шат бүрд сайжруулснаар санхүүжилт зориулалтын дагуу бодитой зарцуулагдаж, барилга стандартын дагуу чанартай баригдаж, санхүүжилтийн бодит гүйцэтгэлд ногдох ажлыг хийлгэсэн.

- Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа чанарын баталгааны барьцаанд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6.-т заасны дагуу гэрээнд ашиглалтад орсон барилгын чанарын баталгааны барьцаа дутуу байршуулсан мөн Техник хяналтын болон нормчлолын сангийн зардлаас гүйцэтгэгчид илүү шилжүүлсэн зөрчлийг арилгаснаар барилгын баталгаат хугацаанд чанарын доголдол гарсан тохиолдолд цаг тухай бүр засварлаж эхэлсэн. Тухайлбал: Баянговь сумын ЗДТГ-ын барилгын ажил хүлээж авах комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулсан.

- “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн /2017-2019 он/” аудитаар орон нутгийн төсвөөс Хасбанкинд байршуулсан 77.8 сая төгрөгийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д шилжүүлж, тус эх үүсвэрээс орон нутгийн ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-д хөнгөлөлттэй зээлийг олгож, аудитын үр өгөөжийг нэмэгдүүлсэн.

- УИХ хурлын болон аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар сонгуулийн үйл ажиллагаанд ашиглах бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг 10,9 сая төгрөгийн хөрөнгийг аймаг, сумын ИТХ-р хөрөнгөөр бүртгэж цаашид сонгуулийн үйл ажиллагаанд дахин ашиглах боломжтойгоор аудитын үр өгөөжийг нэмэгдүүлсэн.

### **3.1 “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудит.**

“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитыг 2020.03.05-ны өдрөөс 20.04.20-ны өдөр 2 аудитор 21 өдөр, 28 илүү цаг 42 хүн өдөр ажиллан гүйцэтгэсэн.

Аудитад 35 байгууллагыг хамруулан шалгаж нийт 8638,6 сая төгрөгийн 13 зөрчил илрүүлснээс Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмыг зөрчин үе шатны ажил бүрэн хийгдэж дуусаагүй байхад 950,0 сая төгрөгийн санхүүжилтийг баталгаажуулан олгосон зөрчлийг арилган ажлыг гүйцэтгүүлэх албан шаардлага, төсөл арга хэмжээний чанарын баталгааны барьцаа хөрөнгийг дансанд байршуулаагүй 121,8 сая, захиалагчийн хяналтын болон нормчлолын сангийн 10,6 сая төгрөгийг гүйцэтгэгчид илүү олгосон зэрэг нийт 132,5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт

тогтоон, төсөв батлагдах үед зураг төсөвт магадлал хийгдээгүй 7556,1 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээний зөрчлийг давтан гаргахгүй байх зэрэг 7 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж, аудитаар 1082,5 сая төгрөгийн үр өгөөж тооцон хүлээн зөвшөөрүүлж, тайланг 2020.04.20-ны өдөр ҮАГ-ын ГАГ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн тооцож ажиллав.

### **3.2 Сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргав.**

Тус гүйцэтгэлийн аудитыг 2020.07.01-ээс эхлэн 2 хүн 14 өдөр 28 хүн өдөр зарцуулж, Баянхонгор аймгийн нийт 21 сонгуулийн хороог хамруулан аудитыг гүйцэтгэж, тайланг 2020.07.24-ний өдөр ҮАГ-ын ГАГ болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн бөгөөд аудитаар 2.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөөгүйгээс 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой 2.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлж ажилласан байна.

### **3.2 Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийв.**

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалтад 2020.10.26-2020.11.13 өдрүүдэд 3 аудитор 15 өдөр, 45 хүн өдөр, 20 илүү цаг ажиллаж, аймгийн Сонгуулийн хороо, 20 сумын Сонгуулийн хороо, 106 хэсгийн хороодод олгосон зардлын хуваарилалт, зарцуулалтыг шалгаж, аудитаар нийт 48.3 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс 2.3 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 45.7 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлснийг хугацаанд нь барагдуулж ажиллав. Аудитаар Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд 2 саналыг ҮАГ-аар дамжуулан аудитын тайланг 2020.11.13 -ны өдөр ҮАГ-т болон аймгийн сонгуулийн хороонд хүргүүлэв. Цаашид сонгуулийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг сумын ИТХ-д орлого авхуулах 8.8 сая төгрөгийн албан шаардлагыг хүргүүлж, санхүүгийн бус үр өгөөжөөр тооцов.

### **3.4. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд аудит хийв.**

Тус аудитыг аймгийн төрийн өмчийн ЕБС-ийн 29 сургууль, төрийн бус өмчийн 1 сургуулийг хамруулан батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 2020.08.30-2020.11.02-нд 4 аудитор хийж гүйцэтгэн 160 хүн өдөр зарцуулан 2020.11.02-ний өдөр аудитын тайланг ҮАГ-т хүргүүлэв.

Аудитаар нийт 378.2 сая төгрөгийн зөрчил илэрч худалдан авалт болон төрийн бус өмчийн сургуульд олгох хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр нь



олгоогүйтэй холбоотой 21.6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, бүртгэл тайлагнал, үр нөлөөтэй холбоотой 8.0 сая төгрөгийн 3 төрлийн албан шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилт, тогтолцоо, дотод хяналт хариуцлага, үр ашиг үр нөлөөг сайжруулах 17 төрлийн зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад тус тус хүргүүлэн 172.1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлж ажиллав. Тогтоосон төлбөрийн 74,5 буюу 16,1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, албан шаардлагаар өгсөн зөрчлийг бүрэн биелүүлж ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

**Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар:**

Тайлант хугацаанд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 6 аудитыг 7 аудитор 131 өдөр, 375 хүн/өдөр, 207 цаг илүү ажиллан 61,8 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэв.

**НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН:**

**Өмнөх онд гүйцэтгэсэн аудит:**

“Иргэн хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх”-д хийсэн аудитаар тогтоосон 7 төлбөрийн актын 55.3 сая төгрөгийн үлдэгдлээс тайлант хугацаанд 21.8 сая төгрөгийг барагдуулж, 33.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй, харин 2 зөвлөмж үлдэгдэлтэй байсныг тайлант хугацаанд хэрэгжүүлэн ажилласан байна.

**Тайлант он гүйцэтгэсэн:**

Нийцлийн аудитаар нийт 2173,5 сая төгрөгийн зөрчил илэрч 1,1 сая төгрөгийн 2 акт, 1830,4 сая төгрөгийн 22 албан шаардлага, 342,0 сая төгрөгийн 15 зөвлөмж хүргүүлэв.

Хүснэгт № 03. Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн нийцлийн аудитын зөрчлийн биелэлт

№	Аудитын нэр	Акт				Албан шаардлага				Зөвлөмж			
		Тоо	Тогтоосон	Барагдсан	Хувь	Тоо	Өгсөн	Барагдсан	Хувь	Тоо	Тогтоосон	Барагдсан	Хувь
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	0	0	0	0.0	1	0	0	100%		0	-	100%
2	Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт	2	1.1	1.1	100%	21	1830.4	1722.4	94.1%	15	342.0		0%
	дүн	2	1.1	1.1	100%	22	1830.4	1722.4	97.1%	15	342.0	0.0	50%

Нийцлийн аудитын албан шаардлага, зөвлөмжийн биелэлт бага байгаа нь “Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн аудитаар өгсөн албан шаардлага болон зөвлөмжийн биелэлт тооцох хугацаа болоогүйтэй холбоотой байна.

**НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ:**

- Өмнөх онд “Ус рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт төлөлтийн байдал хууль тогтоомжид нийцсэн эсэх” –д хийсэн аудитаар өгсөн 1052.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 14 зөвлөмжийн биелэлтийг биелэлтийг холбогдох байгууллагуудаас гаргуулан тооцсон бөгөөд албан шаардлагаас орон нутгийн төсвийн орлогод орсон татварын 25,8 сая төгрөгийг үр өгөөжөөр хүлээн зөвшөөрүүлэн ажиллав.

- ОНХС-ийн 2021 онд төсвийн төсөлд өгсөн үр ашиг нэмэгдүүлэх 340,0 сая, зардал бууруулах 205 сая төгрөгийн саналыг аймгийн ИТХурал хүлээн авч төсвийн төсөлд тусган баталсан.

- “Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээний чанар хүртээмж, үйлчилгээний төрөл, зардлын үр ашиг /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн протез, ортопед үйлчилгээ” аудитын үр дүнд хөнгөлөлт үйлчилгээ авах иргэдийн тоо, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж мэдээллийн сан үүсгэж, мэдээллээр тогтмол хангаж ажилласнаар иргэдэд нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүртээмжтэй олгох нөхцөл бүрдсэн байна.

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт ангийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн аудитаар цаашид түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогын ногдуулалтыг тооцохдоо улс, орон нутгийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажилд шаардагдах элс, хайрганы хэмжээг тооцож төлбөрийн ногдуулалт хийснээр орон нутгийн төсвийн орлого жилд 76.0 сая төгрөгөөр, ан, агнуурын төлбөрийн ногдуулалтыг хийхдээ валютын ханшид хяналт тавьснаар жилд 41.5 сая төгрөгийн төлбөрийн орлогоор орон нутгийн төсөв нэмэгдэх үр дүн бий болсон.

- Шилэн дансны хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитаар улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлэхэд албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг сайжруулж хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлсэн .

**4.1. “Шилэн дансны хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудит.**


Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудитыг 3 аудитор 28 өдөр, 84 хүн өдөр 60 цаг илүү ажиллан 2020.04.01-ээс 2020.05.14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг УАГ-ын НАГ-т 2020.05.14-ны өдрийн 427 тоот албан бичгээр хүргүүллээ. Аудитаар төрийн болон орон нутгийн өмчийн 234 хуулийн этгээдийн 2019 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж 4418 мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хугацаанд нь иж бүрэн мэдээлээгүй зөрчил илэрснээс байршуулаагүй 3387 мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн СТСХ-т хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллав.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, дотоод болон хөндлөнгийн хяналт, албан тушаалтнуудыг хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Санхүүгийн хяналт аудитын албанд хүргүүлсэн ба зөвлөмжийн мөрөөр ТЕЗ-аас “Тунгалаг санхүү” гэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа талаар тайлан, албан бичиг ирүүлснийг нягтлан шалгаж биелэлтийг тооцон ажилласан.

"Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанаас өмнө байршуулан, түүнд холбогдох албан тушаалтнууд хуулийн хугацаанд хяналт тавьж ажиллах зохицуулалтыг хийж ажиллах" зөвлөмж хүргүүлснээр Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг тухай бүр нь мэдээлснээр санхүүгийн бус 2 үр өгөөжийг бүртгэж хүлээн зөвшөөрүүлэв.

**4.2. Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудит.** Тус аудитыг 2020.09.01-ны өдрөөс эхлэн 3 аудитор 120 өдөр, 28 цаг илүү ажиллан гүйцэтгэж, 20 сумын ОНХС, аймгийн ХБХОТХ, СТСХ, гүйцэтгэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамруулав.

Аудитаар нийт 2173.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон 1830.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэн 342.4 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 15 зөвлөмжийг



хүргүүлэн, аудитаас 1.1 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж аудитын тайланг УАГ-т 2020.11.04-ны өдөр хүргүүлсэн, төлбөрийн актаас 1.1 сая төгрөг барагдсан, 1,722.4 сая төгрөгийн 14 албан шаардлагыг биелүүлсэн байна.

**4.3. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох” аудит.**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/52 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал”-ыг баримтлан, зардлын шинжилгээний аудитыг 2020.06.08-ны өдрөөс эхлэн 3 аудитор 36 хүн өдөр зарцуулан батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж хуульд заасны дагуу 2020.06.23-ны өдөр audit.mn сайтаар болон орон нутгийн хэвлэл мэдээллээр нийтэд мэдээлсэн.

**4.4. Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд тухайн нам, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивыг хянаж, баталгаажуулах.**

Сонгуулийн хуулийн дагуу хандивын тайланд хийх аудитыг 2020.07.09-2020.07.22-ны хооронд аудитад холбоотой мэдээллийг холбогдох маягтын дагуу гарган албан тоотоор ирүүлсэн улс төрийн 7 намаас хандивтай холбоотой мэдээллийг хүлээн авч, 3 аудитор 15 хүн өдөр гүйцэтгэж хуулийн хугацаанд дүгнэлт гарган хүргүүлэв. Байгууллагын цахим сайтад нийт 7 хандивын тайланг баталгаажуулсан дүгнэлтийг хуулийн дагуу 2020.09.23-ны өдөр олон нийтэд мэдээлсэн.

**4.5. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах.**

Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах нийцлийн аудитыг 2020.06.25-2020.08.08-ны өдрийг хүртэл 3 аудитор 28 өдөр 84 хүн өдөр зарцуулж аудитыг гүйцэтгэв.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд намуудаас мөрийн хөтөлбөрийг хүлээн авсан ба аймаг сумын нийт 45 намын, 1 бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргаж, 46 сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хамт хуулийн дагуу Сонгуулийн хороо болон намуудад албан бичгээр хүргүүлж ажиллав. Хуулийн 37 дугаар зүйлийн 37.12-т заасны дагуу байгууллагын цахим хуудаст байршуулах мэдээллийн жагсаалт, нам, нэр дэвшигчийн дүгнэлт, мөрийн хөтөлбөрийг PDF файл болгон бэлтгэж, нэгтгэн хянаж 2020.09.23-ны өдөр байгууллагын цахим хуудаст 92 мэдээллийг байршуулсан.

**4.6. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх.**

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд 2 нам, давхардсан тоогоор 898 нэр дэвшигч оролцсоноос Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасныг хэрэгжүүлж аймгийн МАН, АН, Бууцагаан сумын МАН болон 353 нэр дэвшигч хувийн аудитын хуулийн этгээдээр аудитын дүгнэлт гаргуулан Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна. Тус аудитыг 2 аудитор 2020.11.25-ны өдрөөс эхлэн 36 хүн өдөр зарцуулан тайлагналын шатны ажлыг бүрэн гүйцэтгэж хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлэхээр ажиллаж байна.

**Тавдугаар бүлэг. ИТХ-ын захиалга болон өөрийн санаачилга:**

Тайлант онд аймгийн ИТХ-ын захиалгаар 2 нийцлийн аудит, байгууллага өөрийн санаачилгаар 2 гүйцэтгэлийн аудитыг 5 аудитор 664 хүн/өдөр зарцуулан 109.4 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэсэн.

Аудитаар нийт 1,347.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 37.8 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 477.9 сая төгрөгийн 16 албан шаардлага хүргүүлж, зөрчил арилгах 831.6 сая төгрөгийн 42 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, 512.4 сая төгрөгийн 11 санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж ажиллаа.

Хүснэгт №04. Аймгийн ИТХ болон өөрийн санаачилгаар хийсэн аудитын зөрчлийн биелэлт /сая төгрөг/

№	Аудитын нэр	Акт				Албан шаардлага				Зөвлөмж			
		тоо	тогтоосон	барагдсан	хувь	тоо	өгсөн	биелсэн	хувь	тоо	өгсөн	биелсэн	хувь
1	Аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэсэн аудит	2	3.5	3.5	100%	7	125.1	125.1	100	22	361.5	361.5	100%
2	Байгууллага өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн аудит	4	34.3	26.2	76%	9	352.8	256.8	73%	20	470.1	470.1	100%
	Нийт	6	37.8	29.7	88%	16	477.9	381.9	73%	42	831.6	831.6	100%

**Баянхонгор аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэсэн аудит:**

**5.1 “Нийгмийн халамжийн хөнгөлөлт үйлчилгээний чанар хүртээмж, үйлчилгээний төрөл, зардлын үр ашиг /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн протез, ортопед үйлчилгээ”-д хийсэн аудит.**

Баянхонгор аймгийн ИТХ-ын захиалгаар нийцлийн аудитыг аймгийн нийгмийн халамжийн сангийн 2016-2019 оны үйл ажиллагааг хамруулан 2020.05.12-ны өдрөөс эхлэн 3 аудитор 34 өдөр, 80 хүн өдөр гүйцэтгэж, аудитаар нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг төлөвлөхдөө бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлаагүй, хөнгөлөлт, тусламж олгохдоо шаардлагатай баримтын бүрдэл дутуу, хуулийн шаардлага хангаагүй байхад иргэдэд хөнгөлөлт тусламж олгосон, хөрөнгийн зарцуулалтад тавих хөндлөнгийн болон дотоод хяналтыг тухай бүр бүрэн хэрэгжүүлээгүйгээс нийт 134.7 сая төгрөгийн 11 зөрчил илрүүлснээс 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.4 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 133.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад өгч, аудитын тайланг 2020.07.02-ны өдөр аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад хүргүүлэн аудитаар илэрсэн зөрчлийн хэрэгжилтийг

бүрэн тооцож ажиллаа. Аудитаар тогтоосон 1.0 сая төгрөгийн төлбөрийн актыг үр өгөөжөөр хүлээн зөвшөөрүүлсэн.

### 5.2 “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт ангийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн аудит

Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 3 аудитор 34 өдөр, 90 хүн өдөр 2020.06.01-2020.07.09-ний хооронд гүйцэтгэн, байгалийн нөөц ашигласны төлбөр, ангийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогыг 2016-2019 оныг хамруулан шалгаж, аудитаар 355.4 сая төгрөгийн 24 зөрчил илэрч аудитын тайланг тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 124.7 сая төгрөгийн 4 албан шаардлага, 228.2 сая төгрөгийн 19 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан ба аудитаар 120,0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн.

#### Байгууллага өөрийн санаачилгаар хийсэн аудит:

Байгууллага өөрийн санаачилгаар 2 гүйцэтгэлийн аудитыг 5 аудитор 37 өдөр 30 цаг илүү ажиллан гүйцэтгэж, нийт 857.2 сая төгрөгийн 32 зөрчил илэрч, 34.3 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 352.8 сая төгрөгийн 10 албан шаардлага өгч, 470.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 20 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, 112.1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг тооцож ажиллав.

Өмнөх онд гүйцэтгэсэн “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны үр дүн” аудитаас хүлээн зөвшөөрсөн санхүүгийн 253.5 сая, тайлант онд 1,370.1 сая, нийт 1,623.6 сая төгрөгийн санхүүгийн, санхүүгийн бус 3 үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж бүртгэлээ.

Хүснэгт№05 Байгууллага өөрийн санаачилгаар	Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт						сая.төг		
	Акт			Албан шаардлага			Зөвлөмж		
	тоо	дүн	хувь	тоо	дүн	хувь	тоо	дүн	хувь
Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэл	0	0	0	2	205.8	100%	10	470.1	100%
Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн /2017-2019 он/	3	26.2	0	3	51	35%	10	0	100%
Нийт	3	26.2	76%	5	256.8	73%	20	470.1	100%

### 5.3 “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн аудит.



Аудитыг 14625.0 мянган төгрөгийн өртгөөр 2020.05.15-аас 2020.06.15-ны хооронд 2 аудитор 22 өдөр, 44 хүн өдөр гүйцэтгэсэн. Аудитаар Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжүүлэх сангаас 2019 онд хуваарилсан 1000.0 сая төгрөгийн санхүүжилтээс 26 иргэнд олгосон 681.0 сая төгрөгийн зээлийн зарцуулалтыг бичсэн төсөлтэй харьцуулан шалгаж, ажлын байр нэмэгдсэн байдлыг газар дээр нь үзэж шалгаж гүйцэтгэлээ.

Төсөл сонгон шалгаруулах дэд хороо холбогдох журам, чиглэлийг баримталж ажиллаагүйгээс бусад санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 3 иргэн, аж ахуйн нэгжид зээлийг давхардуулан олгосон, зарим зээлдэгч төсөлд заагдсан зориулалтын дагуу зээлийг ашиглаагүй, ажлын байрыг нэмэгдүүлээгүй зэрэг зөрчил аудитаар илэрч, 34.3 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 147.0 сая төгрөгийн 7 албан шаардлага, 10 зөвлөмжийг аймгийн ХХААГ, Монгол банкны салбарт хүргүүлж, аудитаар 112.1 сая төгрөгийн үр өгөөж тооцож ажиллав.

Тогтоосон төлбөрийн актын 76.4%, албан шаардлагын 34.7 хувийг биелүүлж ажилласан бөгөөд 2020 онд Дэлхий нийтэд гарсан цар тахалтай холбоотой хөл хорио тогтоосны улмаас бизнес эрхлэгч нар тоног төхөөрөмжөө аваагүй, үйл ажиллагаа эрхлээгүйтэй холбоотой төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн биелүүлэх боломжгүй болсон тул дараагийн онд шийдвэрийн хэрэгжилтийг шалгахаар болов.

#### **5.4 “Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудит**

Аудитыг 2020.03.31-2020.04.20 хугацаанд 3 аудитор 15 өдөр зарцуулан гүйцэтгэж, 675,9 сая төгрөгийн зөрчил илрүүлсний дотор төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасан бүрэлдэхүүнээр гаргаж ирүүлдэггүй, аймаг, сумдын ИТХ-ын баталсан тогтоолыг төсвийн мэргэжилтнүүд хянаж хүлээн аваагүйгээс Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн программд зөрүүтэй оруулсан, төсөвт байгууллагуудын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс төсвийн жилийн дундуур төсөвт зохицуулалт хийж, шийдвэрийг нөхөн гаргасан, сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн орлого, хугацаа хэтэрсэн зээлийн авлагад тавих хяналт хангалтгүйгээс тайлант оны орлогын төлөвлөгөө тасарсан, сумдын соёлын төвүүд орлого бүрдүүлэх талаар санаачилгагүй ажилласнаас 11 соёлын төв тайлант онд нэг ч төгрөгийн орлого оруулаагүй, аймгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг Татварын хэлтсийн мэдээнээс зөрүүтэй илэрхийлсэн байна.

Аудитаар 205.8 сая төгрөгийн 2 албан шаардлага, 470.1 сая төгрөгийн 10 зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэв.

**Зургаадугаар бүлэг. Дотоод ажил:****Хүний нөөцийн талаар:**

Байгууллагын батлагдсан орон тоо 11, тайланд оны эхэнд үндсэн 9 ажилтан, түр орлон гүйцэтгэгчээр 2 аудитор, санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд гэрээт аудитор 2, Төсөвт тусгагдсаны дагуу байгууллагын нярав, архив бичиг хэргийн 1 ажилтан ажилласан.

МУЕА-ын тушаалаар 2017-2020 онд хүүхэд асрах чөлөөтэй байсан 2 ажилтны хугацаа дуусаж 5, 8-р сард ажилдаа орсон.

Төрийн аудитын байгууллагын 2019-2024 оны стратегийн “Нийгмийн бүхий салбарыг хамарсан өргөн хүрээний асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх мэдлэг, чадвар бүхий хүнийг нөөцийг бүрдүүлэх” зорилгын хүрээнд чадвартай, мэргэшсэн, төрийн албаны нөөцөд байгаа иргэнийг албан тушаал дэвшүүлэх, ажилд авах бодлогын баримтлан 2019 оноос нэг ахлах аудитор дутуу явж ирсэн ба төрийн албаны шаардлага хангасан аудиторыг ахлах аудитораар түүний сул гарсан орон тоон дээр түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан төрийн албаны нөөц бүртгэлтэй иргэнийг томилуулах саналыг МУЕА-т хүргүүлэн 2020 оны 9 дүгээр сард томилуулснаар бүрэн орон тоогоор /11/ ажиллаж байна.

Дээрх зорилгын хүрээнд байгаа нөөцийнхөө суурь боловсрол, мэргэшилд тулгуурлан боловсон хүчнийг чадваржуулах зорилгоор мэргэшсэн нягтлан бодогч, хөрөнгийн үнэлгээчин, татварын мэргэшсэн зөвлөх, мэргэшсэн төсөвчин зэрэг илүү мэргэшүүлэх тал руу сургалтын төлөвлөгөөгөө боловсруулж байна.

Тайлант хугацаанд хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээлэл, тайланг хугацаанд нь тогтмол ҮАГ-ын хүний нөөцийн ажилтантай тулгалт хийж Төрийн албаны хүний нөөцийн систем болон ABLE-д ажилтнуудын мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулав.

Тайлант оны 05 дугаар сард нийт ажилтнуудыг Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, бүх төрлийн шинжилгээг өгсөн. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн зүрх судасны эмчтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнд судалгаа хийж 12 дугаар сарын 25-нд эрүүл мэндийн сургалтад ажилтнуудыг хамруулахаар болсон.

**Мэдээ тайлан гаргалтын талаар:**

Байгууллагын 2020 оны эхний хагс жилийн статистик мэдээг батлагдсан маягтын дагуу гаргаж, тайлан бичиж СУГ-т хүргүүлсэн.

Одоо 2020 оны жилийн эцсийн статистик мэдээг батлагдсан маягтын маягтын дагуу гаргаж тайлан бичиж хүргүүлэхээр бэлтгэсэн, 2020 оны 12 дугаар сарын 18-нд хугацаанд нь ҮАГ-ын СУГ-т хүргүүлнэ.


Байгууллагын 2020 оны 1,2,3 дугаар улирал Гүйцэтгэлийн тайланг гарган ҮАГ-ын Тамгын газарт, мөн 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг урьдчилсан байдлаар 2020.06.25-ны өдөр гарган ҮАГ-ын Тамгын газарт хугацаанд нь гаргаж хүргүүлсэн ба жилийн эцсийн Гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээг бэлтгэн ҮАГ-ын СУГ, Тамгын газарт тус тус хүргүүлэв.

Байгууллагын сарын ажлын тайланг сар бүр гаргаж, ҮАГ-ын МУЕА-ын Орлогчид тогтоосон хугацаанд тогтмол хүргүүлсэн.

ҮАГ-ын СУГ, НАГ, ГАГ, ХШУДАГ, Тамгын газраас цаг үеийн ажилтай холбогдож шаардсан мэдээ, мэдээлэл, судалгаа, ажлын тайланг тухай бүр гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

### Цахим сургалтын талаар:

Байгууллагын бүх албан хаагчид Төрийн аудитын цахим сургалт хөгжлийн хөтөлбөрийн дагуу 2020 оны 10-11 сард Хуулийн хэрэглээ хичээл буюу “Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга” хичээлийг судлан хичээлийн явцын болон сүүлийн сорилд 11 ажилтан хамрагдан байгууллагын дундаж үнэлгээгээр 90 хувьтай үнэлэгдлээ.



Өндөржүүлсэн бэлэн байдал, хорио цээрийн улмаас ҮАГ-аас Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан "Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц" цахим сургалтад 2 ахлах аудитор оролцож цахимаар шалгалт өгч “Ахлах түшмэл”-ийн гэрчилгээ авсан.


### Дотоод сургалтын талаар:

Төрийн аудитын газрын мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийн хүрээнд Төрийн аудитын байгууллагын 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд 9 санал тусгуулж, танхимаар 17 сургалт, онлайн сургалтад 7 сургалтад хамрагдах саналаа нэгтгэн хүргүүлсэн ба Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/30 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2020 оны сургалтын чиглэл, ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу тус газрын 2020 оны дотоод сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан, байгууллагын ажилтнуудад зориулсан 2020 оны дотоод

сургалтын хөтөлбөр боловсруулан баталж, календарчилсан хөтөлбөрийн дагуу хорио цээрийн дэглэмийг мөрдөн зарим сургалтыг явуулсан.

2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр Монгол улсын Ерөнхий аудиторын 2019.11.12-ны өдрийн А/87 тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын программд санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлыг гүйцэтгэх, санхүүгийн тайлангийн аудит хийхэд анхаарах зүйл, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулж, тайлагнах, архив, албан хэрэг хөтлөлт, архивын хадгаламжийн нэгж боловсруулах арга зүй, шинээр батлагдсан Төрийн аудитын тухай хуулийн талаар аудиторуд, ХАК-ны аудитор нарт 10 удаа сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 116 хүн хамрагдаж 42 цагийн сургалт хийсэн байна.

2020 онд дэвшүүлсэн “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” зорилтын хүрээнд дарга, тэргүүлэх аудитор нарт зориулсан нэгдсэн сургалтад 2020 оны 5 дугаар сарын 29-нд хамрагдсан, шинэчлэн батлагдсан “Төрийн аудитын тухай хууль”-ийн дарга, тэргүүлэх аудитор сургалт хийж, “Төрийн аудит” MNS 6817:2020 Монгол улсын стандартыг ажилтнууд аудитад ашиглаж, судалж хэрэглэж байна.



ИНТОСАИ-ийн Мэдээллийн технологийн аудитын ажлын хэсгээс Бүгд найрамдах Энэтхэг улсын хянагч бөгөөд Ерөнхий аудиторын газар, Бүгд найрамдах Унгар улсын ТАГ-тай хамтран Мэдээллийн технологийн аудитын сэдвээр улс орнуудын танилцуулга хийх цахим семинарт хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням 2020.10.16-ны өдөр оролцов.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Хүний нөөцийн аудит" сургалтад 1, "УСННБОУС-ын мэдлэгийг дээшлүүлэх" 12 цагийн сургалтад 3, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтад 4, МНБИ-ээс зохион байгуулсан онлайн сургалтад 2, "SEATTLE ESL school-ийн 3 сарын онлайн курс 1 ажилтан тус тус оролцож мэргэжлийн болон хэлний мэдлэгээ дээшлүүлсэн.

### Олон нийттэй харилцах ажлын талаар:

Санхүүгийн тайлангийн аудитын нэгдсэн дүгнэлтийн талаарх мэдээлэл, гүйцэтгэлийн болон нийцлийн аудиттай холбоотой 9 мэдээг Өнөөгийн Баянхонгор сонины

мэдээнд өгсөн. Байгууллагын цахим хуудаст санхүүгийн тайлангийн дүгнэлтийн талаарх жагсаалт болон гүйцэтгэсэн аудитаар илэрсэн 198 акт , 136 албан шаардлага, гүйцэтгэл нийцлийн аудитын болон цаг үетэй холбоотой нийт 158 мэдээллийг байршуулан ажилласан байна.

2020 онд гүйцэтгэсэн аудитын тайланг давхардсан тоогоор 277 байгууллагад хүргүүлж, мөн хүсэлтийн дагуу 26 аудитын тайланг бусдад хувилж өгсөн. Мөн Санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн тухай танилцуулга, зөвлөмж бэлтгэж аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргад хүргүүллээ.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ, Санхүүгийн хяналт дотоод аудитын албатай хамтран 5 дугаар сард 2020 онд хийсэн Санхүүгийн тайлангийн аудитын дүн, Шилэн дансны аудитаар илэрсэн зөрчил дутагдал цаашид анхаарах асуудлын талаар 20 сумдын Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нар мэдээлэл өгч, ярилцлага хийв.

### **Мэдээлэл технологийн ажлын талаар:**

Тайлант хугацаанд сүлжээний доголдол 1 удаа гарсан бөгөөд сүлжээний тэжээлийн залгуур шатсан байсныг шуурхай хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн аудиторуудын компьютерыг хэвийн ажиллах нөхцөлийг хангаж үйлдлийн систем шинэчилсэн. "Болор дуран" программыг 6 аудиторын компьютерт, 5 албан хаагчийн компьютерт үйлдлийн систем шинэчлэн суулгасан, мөн 2 компьютерын их хавтан шатсаныг засварлуулж хэвийн ажиллагаанд оруулж, гарсан гэмтлийг тухай бүр нь засварлуулан ажиллав.

ҮАГ-ын мэдээлэл технологийн албанаас нэгдсэн журмаар суулгасан хортой кодын эсрэг программыг суулгасан бөгөөд компьютерын болон тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажилласан.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх үндсэн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох зорилготой "ДИЖИТАЛ АУДИТ 2025" цахим линк дэх судалгаанд 8 ажилтан хамрагдаж саналыг нэгтгэн СУГ-т хүргүүлсэн.

"ТАБ-ын мэдээллийн технологийн бодлого" /2020-2025 он/ -ын баримт бичгийн төсөлд аудиторуудаас саналыг авч нэгтгэн 5 саналыг СУГ-т 2020.05.22-нд хүргүүлэв.

ҮАГ-ын Мэдээллийн технологийн албанд цахим гарын үсгийг нэвтрүүлэхтэй холбогдуулан ажилтнуудын албан хаягийн бүртгэл, шаардлагатай баримт бичгийн хамт 2020.06.15-нд хүргүүлсний дагуу ҮАГ-аас цахим гарын үсгийн "И-токен" кодыг хүлээн авсан.

Мөн нэмэлт санхүүжилтээр 8,0 сая төгрөгийн эрх нээж өгсний дагуу албан хаагчдад 2 суурин компьютер, 1 зөөврийн компьютер, 2 хэвлэгч, 1 хурдны сканер авч техник тоног төхөөрөмжийг шинэчилснээс гадна ҮАГ-аас ирсэн сүлжээний төхөөрөмжийг шинэчлэв.

**ХАСХОМ, Нууц хамгаалах ажлын талаар:**

Төрийн аудитын байгууллагын албан тушаалтны ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2020.01.21-2020.01.24-ний өдрийн хооронд хүлээн авч хянан, www.meduuleg.iaac.mn сайтаас холбогдох тайлангуудыг гаргаж баталгаажуулж, дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталгааны хуудасны хамт УАГ-т хүргүүлэв.

Санхүүгийн 1, гүйцэтгэлийн 1 аудиттай холбоотойгоор үүссэн Тэргүүлэх аудиторын мэдэгдлийг МУЕА-н Орлогч даргад хүргүүлж, Ахлах аудитор М.Алтантуяа Нийцлийн 1 аудит гүйцэтгэхтэй холбоотой зөрчил үүссэн тухайг мэдэгдлийг, аудитор П.Амаржаргал авто тээврийн хэрэгслийн дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой зөрчил үүссэн тухайг мэдэгдлийг, ахлах аудитор Б.Азбаяр санхүүгийн тайлан гүйцэтгэхтэй холбоотой зөрчил үүссэн тухай мэдэгдлийг, тус тус байгууллагын дарга бөгөөд Тэргүүлэх аудитораар шийдвэрлүүлснийг байгууллагын цахим хуудаст байршуулж, www.meduuleg.iaac.mn сайтад мэдээллийг оруулж ажиллав.

**Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаар:**

Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх танилцуулгыг бэлтгэж, албан бичгээр УАГ-т болон Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтэст 2020 оны 01 дүгээр сарын 27-нд хүргүүлж ажиллав.

Тайлант хугацаанд аудитыг гүйцэтгэж байгаа аудитор болон албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулан авч, шинээр 3 лац нэмж захиалснаар ажилтнууд бүгд лацтай болсон ба тайлант онд лац ашиглаж байгаа ажилтан өөрчлөгдсөн тухай бүр лацны бүртгэлийг шинэчилж ажиллав.

Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу 2019.12.20-2020.02.05-ний хооронд гадаад улсад зорчсон албан хаагчдын судалгааг гаргаж, 2020.02.07-нд, хагас жилийн судалгааг 2020.06.29-нд хүргүүлэв.

Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудитаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж байгаа, учруулж болзошгүй эрсдэлтэй асуудал гараагүй, аудитын тайланг тухай бүр нь аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж ажилласан тухай албан бичгийг аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст 2020.07.02, 2020.12.04-нд хүргүүлэв.

**Архив, бичиг хэргийн хөтлөлтийн талаар:**

Аймгийн Архивын тасгаас гаргасан хуваарийн дагуу 2017 оны байнга хадгалах 28 төрлийн баримтыг архив албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу шалгуулан цаасан болон цахим хэлбэрээр ашиглалтын хувь үүсгэн, цэвэрлэгээ хийж, нүүр дотоод товъёг, баримт



ашиглалтын баталгааны хуудас үйлдэн 1 дүгээр үдэлт хийж, цахим сан үүсгэхээр аймгийн Төрийн архивын тасагт шалгуулан ажиллаж хүлээлгэн өгч хяналтыг хийлгэн ажиллаж байна.

Архив, бичиг хэргийн ажилтан 2020 оны 4 болон 10 дугаар сарын 1-ны өдрөөр тасалбар болгон солигдож байгаатай холбогдуулан 1996-2020 оны 10 сар хүртэлх баримтын тооллогыг иж бүрэн хийж, баримтыг хөтлөх хэргийн жагсаалтай тулган ажил хүлээлцэх акт үйлдэн, баталгаажуулав.

Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комисс нь 2020 онд 9 ажил хийхээр төлөвлөгөөг боловсруулан батлуулснаас ажлыг бүрэн хийж хэрэгжүүлэн. Төлөвлөсөн ажлын ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Байгууллагын 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан аймгийн Архивын тасагт хүргүүлж, саналыг авч баталгаажуулсан.
- Аймгийн Архивын тасгаас гаргасан хуваарийн дагуу 2017 оны байнга хадгалах 28 төрлийн баримтыг архив албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу шалгуулан цаасан болон цахим хэлбэрээр ашиглалтын хувь үүсгэн бичиг хэргийн ажилтан 2020.07.01-нд хүлээлгэн өгсөн.
- 2019 онд хийсэн аудитын ажлын баримтыг архивд бүрэн өгсөн эсэхэд шалгалт хийхэд 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг ажилтнууд хадгаламжийн нэгж болгон жагсаалтаар хүлээлгэн өгснийг бичиг хэргийн ажилтан хадгалах хугацаагаар ангилан архивлаж байна.
- Байгууллагын албан хэвлэмэл хуудасны тооллогыг ажил хүлээлцсэн 4, 10 сар болон төлөвлөгөөний дагуу 12 дугаар сарын 01-нд хийж, акт үйлдэн баталгаажуулж, илтгэх хуудас дүнг аймгийн Төрийн архивд хүргүүлж ажиллав.
- 2020 онд хийсэн аудитын баримтыг архивд өгсөн эсэхэд шалгалт хийхэд аудиторуд санхүүгийн 184, гүйцэтгэл болон нийцлийн аудитын 11 аудитын баримтыг архивын нэгж цаасан баримтыг сканердаж цахим файл үүсгэн Төрийн архивын стандарт шаардлагын дагуу хүлээлгэн өгсөн байна. Энэ ажил нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан шинэ бүтээлч ажил байсан. Тайланг тусад нь хүргүүлсэн.

Архивын ажилтан нь архивын өрөөнд байвал зохих галын аюулгүйн тэмдэг, галын хор, хүрз, температур болон чийг хэмжигч, элс, ус хадгалах сав, баримт зөөх уут, камержуулалд зэрэг шаардлагатай багаж хэрэгслийн бүрэн байдалд хяналт тавин, өрөөний агааржуулалт температурыг тогтмол шалгаж, стандартын дагуу хяналт тавин ажиллаж байна.

2020 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 557 албан бичиг ирснийг Able программ болон бүртгэлийн дэвтэр ашиглан бүртгэл хөтлөн холбогдох албан тушаалтнуудад шилжүүлсэн, байгууллагаас гаргасан 776 албан бичгийг цаасаар болон Able программ ашиглан бүртгэл хөтлөн тухай бүрд байгууллагуудад хүргүүлж ажиллав.

Бичиг хэргийн ажилтан 2020 онд аудитаар тогтоосон 198 төлбөрийн акт, 136 албан шаардлагыг тухай бүр нь баталгаажуулан хүргүүлж байгууллагад үлдэх хувийг PDF файлыг дарааллын дагуу үүсгэн цахим хэлбэрээр хадгалж, цаасан баримтыг үдэж архивын нэгж үүсгэхэд бэлэн болгосон байна.

Байгууллагын архивд 1995-2020 он хүртэл аудитын тайлан, шалгалтын материал хадгалагдаж байгааг төрийн архивд шилжүүлэн цахимд оруулах талаар судалж, Төрийн архивын тасгаар гэрээний дагуу хийлгэхээр урьдчилан төлөвлөгөөний төсөл гаргаж холбогдох зардлыг тайлант он, оноор тухайн байгууллагын төсөвт суулгах талаар аймгийн ЗДТГ-ын СТСХ-тэй ярьж, ажлыг 2021 оноос эхлэн хийхээр төлөвлөөд байна.



### Долдугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл:

Байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, Улаанбаатар хотын “Грант Торнтон аудит” ХХК-аар аудит хийлгэн “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба зөвлөмжийн хэрэгжилтийг 2020.06.25-ны өдрийн 1/461 тоот албан бичгээр “Грант Торнтон аудит” ХХК-д цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

Байгууллагын эд хөрөнгийн эхний хагас жилийн тооллого хийх комиссыг дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовын 2020.06.15-ний А/56 тоот тушаалаар байгуулж, тооллогыг 6 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд хийсэн, тооллогод 118 нэр төрлийн 197,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 224 нэр төрлийн 9.5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын дүнг байгууллагын өмч хамгаалах зөвлөлд танилцуулж, тооллогын дүнг баталгаажуулсан. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг Газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовын А/39 дугаар тушаалаар 2020 оны 12 дугаар сарын 15-16-нд хийсэн.

Тус газар нь УАГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 03/3045 тоот албан бичиг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 484 тоот тогтоолын дагуу УАЗ Фургон авто тээврийн хэрэгслийг худалдах нээлттэй дуудлага худалдааг 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, 14 иргэн оролцож иргэн Т.Ариунболд 12,7 сая төгрөгөөр ялж Өмч хувьчлалын орлогын Төрийн сан банкны 100900000721 тоот дансанд 12.6 сая төгрөгийг 2020.12.07-ны өдөр төвлөрүүлж, 0.1 сая төгрөгийг дуудлага худалдаа зохион байгуулах зардалд зарцуулж дуудлага худалдааны холбогдох бичиг баримтын хуулбарыг ТӨБЗГ болон УАГ-т хүргүүлэв.

Байгууллагын 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг санхүүгийн “Unicus программ”-д ажил гүйлгээг тухай бүрд нь бүртгэж 2020.07.03-ны өдрийн 1/519 тоот албан бичгээр ҮАГ-н Тамгын газарт хүргүүлсэн байна.

ҮАГ-ын Тамгын газар ерөнхий санхүүчийн өгсөн үүрэг, даалгавар чиглэлийн дагуу Төрийн албаны цалингийн нэгдсэн системд 2020 оны 4 дүгээр сараас эхлэн 11 хүний цалингийн мэдээллийг нөхөн оруулж цалин бодолтыг цалингийн нэгдсэн систем болон байгууллагын дотоод санхүүгийн программаар хийж байна. Мөн ерөнхий санхүүчийн 2020.10.26-ны өдрийн able программын шуурхай мессежээр өгсөн “Төсвийн 11 сарын хуваарийн өөрчлөлт хийгдэх болон урагш татах зардлын саналыг 19-ны дотод ирүүлнэ үү” гэсэн чиглэлийн дагуу хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 2020.09.19, 2020.10.19-ны өдрүүдэд тус тус байгууллагын албан хаягаар ерөнхий санхүүчид хүргүүлсэн.

Тайлант хугацаанд хийгдсэн төсвийн зохицуулалтаар эд хогшил урсгал засварын зардалд батлагдсан 8.0 сая төгрөгийн төсвөөр ТБОНӨХБАҮХ авах тухай хуулийн хүрээнд шууд гэрээ байгуулан худалдан авах ажил зохион байгуулан дутагдаж байгаа техник тоног төхөөрөмжийн эрэмбэ тогтоон чухал шаардлагатай байгаа суурин компьютер 2 ширхэг, зөөврийн компьютер 1 ширхэг, принтер 2 ширхэг, хурдын сканер 1 ширхэг, компьютерын дэлгэц 2 ширхэг нийт 5 төрлийн 7,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч байгууллагын үндсэн хөрөнгөнд орлогоор бүртгүүлэх хүсэлтийг ТӨБЗГ-т уламлаж өгөх хүсэлтийг 2020.11.27-ны өдрийн 1/761 тоот албан бичгээр ҮАГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна.


### Орлогын гүйцэтгэл: Жилийн эцсийн ХБГ-ээр

2020 онд 444,5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас жилийн эцсийн байдлаар 414,5 сая төгрөгийн санхүүжилтийг авч зардлын бүлэг тус бүрээр зориулалтын дагуу зарцууллаа. Тайлант оны эхний 8 сард нэг орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардал, дэлхий даяар цар тахал гарсантай холбоотойгоор 4-р улиралд томилолтын бусад зардал хэмнэгдэж хэмнэлтийг төсвийн зохицуулалт хийлгэн хуваарьт өөрчлөлт оруулсан.



### Зардлын гүйцэтгэл: Жилийн эцсийн жилийн ХБГ-ээр

Тайлант онд 414.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа явуулахаар төсөв батлагдсанаас жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр цалингийн зардалд 322.1 сая, НДШ-ын зардалд 40.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 41.6 сая төгрөг, ХБГ-ээр нийт 403.8 сая төгрөгийг зарцуулсан байна.



Нэмэлт санхүүжилтийн дансанд 2020 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн

байдлаар санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөр 46,8 сая төгрөг төвлөрснөөс Хувийн аудитын компанитай байгуулсан гэрээний дагуу Хонгорын үр сад ХХК-д 7,1 сая, Глобал аудит ХХК-д 7,3 сая төгрөгийг тус тус олгож, харилцах данс 34.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн шууд захирагчийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг боловсруулан уламжлалт болон ҮАГ-ын хэмжээнд шинээр нэвтрүүлж буй “Төлөвлөгөөний программ v2.2” программаар боловсруулж ҮАГ-ын Хөрөнгө оруулалт төлөвлөлтийн хэлтэст цаасан болон цахим хэлбэрээр 2020.04.17-ны өдрийн 1/410 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Төсвийн гүйцэтгэл, авлага өглөг, Нийгмийн даатгалын НД7,8 мэдээг сар бүр, Татварын тайланг улирал бүр гарган баталгаажуулан ҮАГ, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэст цахим болон цаасан хэлбэрээр хугацаанд нь хүргүүлсэн байна.

### Шилэн дансны мэдээллийн талаар:

Тайлант онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллийг байршуулахаас 132 мэдээлэл хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Шилэн дансны цахим хуудас 2 дугаар сард нэвтэрч орж болохгүй мэдээлэл оруулах боломжгүй байсантай холбоотойгоор тухайн сарын мэдээллүүд хугацаа хоцорсон байна.

